



START
NETWORK



World Vision
ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ

УГТАЖ ХАР, ТОСОЖ БЭЛД, ТЭСЭЖ ДАВ


Хээрийн түймрийн эрт арга хэмжээ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад хээрийн түймрийн давтамж жилээс жилд нэмэгдэж орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Ган гачиг, дэлхийн дулаарал түймрийн давтамжийг улам бүр нэмэгдүүлж байгаа бөгөөд 2023 оны Онцгой байдлын ерөнхий газрын “Ой хээрийн түймрийн тохиолдлын тайлан”-д дурдсанаар 130 гаруй түймэр бүртгэгдэж, 2.4 сая га талбай шатсан ба 230,000 хүн ялангуяа малчид ихээхэн хохирол амсжээ. Сумдын нутагт тархмал суурьшсан айл өрхүүд гал түймрийг тухай бүрд нь унтраах, хариу арга хэмжээг түргэн шуурхай авах нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг учраас хээрийн түймэр тархах нэг үндсэн шалтгаан болдог. Иймээс “Хээрийн түймрийн эрт арга хэмжээ” төсөл нь иргэдийн мэдлэг, чадавхыг дээшлүүлж, орон нутгийн нөөцийг бэхжүүлэх замаар урт хугацааны тогтвортой үр дүнг бий болгохоор зорьж байна.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

- **Хугацаа:**
2025 оны 4-р сарын 15 - 5-р сарын 30 (45 хоног)
- **Хэрэгжих байршил:**
 1. Дорнод аймаг: Баян-Уул, Матад, Халхгол сум
 2. Хэнтий аймаг: Батширээт, Баян-Овоо, Биндэр, Норовлин сум
 3. Сүхбаатар аймаг: Асгат, Дарьганга, Эрдэнэцагаан сум



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Малчид болон сумдын зөвлөлд түймэр унтраах хэрэгсэл, хувцсаар хангах.
2. 100 сайн дурын ажилтанд түймрээс сэргийлэх, эрт хариу арга хэмжээний мэдлэг олгох.
3. 3000 өрхөд “Галын эрсдэлийн үнэлгээний хэвлэмэл материал” тараах.
4. Шуурхай харилцаа холбооны зорилгоор 13 Starlink төхөөрөмжөөр хангах.

ҮР НӨЛӨӨ

Төсөл нь хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эрт хариу арга хэмжээ авах боломжийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, тогтвортой амьдралыг хангахад хувь нэмэр оруулах юм.

АСААСАН БОЛ ЗААВАЛ ГҮЙЦЭД УНТРАА
ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭР



АЮУЛГҮЙ ИРЭЭДҮЙ АЙЛ ӨРХӨӨС...

Холбоо барих:

+976-70111501

info.mongolia@peopleinneed.net

www.mongolia.peopleinneed.net



101 - Гал

102 - Цагдаа

103 - Эмнэлэг

105 - Онцгой байдал

108 - Хүүхдийн тусламжийн утас